



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2021 оны 27 болон 28 дахь долоо хоног

ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2021 оны 07-р сарын 03-наас 07-р сарын 20-ны байдлаар

Ковид-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас 2 долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 2021 оны 11 дэх дугаарыг хүргэж байна.

1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- **АНУ-ын хэрэглээний үнийн индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2021 оны 6-р сарын байдлаар 5.4 хувиар өсөөд байна.** Энэ нь Dow Jones байгууллагын төсөөлөл болох 5 хувиас давсан үзүүлэлт боллоо. Өсөлтөд эрчим хүч, хүнс, хуучин машины үнэ голлон нөлөөлсөн бөгөөд ХНБ-аас энэ нь түр зуурын үзэгдэл гэдгийг мэдээлэв.
- **АНУ-ын шинээр зарлагдаж буй ажлын байрны тоо энэ оны эхний 5 сарын байдлаар нийт 9.2 саяд хүрч байсан бол 6-р сард 850 мянган шинэ ажлын байр нэмж зарлагдаад байна.** Гэсэн хэдий ч хөдөлмөрийн зах зээл ажиллах хүчний хомсдолд орсон хэвээр байгаа нь Засгийн газраас зарласан ажилгүйдлийн тэтгэмжийн хөтөлбөр 9-р сар хүртэл үргэлжлэхтэй холбоотой гэж таамаглаж байна. Ажиллах хүчний хомсдол нь жижиг дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа зогсох нөхцөл байдал үүсгэж болзошгүйг эдийн засагчид анхаарууллаа.
- **Японы Төв банк 2021 оны эдийн засгийн өсөлтийн төсөөллөө 0.2 хувиар бууруулж 3.8 хувь болголоо.** Цар тахлаас шалтгаалан хатуу хөл хориог үргэлжлүүлэн тогтоож байгаа нь эдийн засагт сөргөөр нөлөөлж байна. Түүнчлэн тус улсын гадаад болон дотоод орчны эрсдэл өндөр хэвээр байгаа нь төсөөллийг бууруулахад нөлөөлөв. Харин ирэх жилийн төлөвөө 2.4 хувиас 2.7 хувьд хүргэж нэмэгдүүлжээ. Японы Төв банкнаас эрчим хүч болон түүхий эдийн үнийн өсөлтөөс шалтгаалан инфляцын төсөөллөө 0.1 хувиас 0.6 хувь болгон нэмэгдүүлэв. Мөн Японы Төв банкнаас зарласан ногоон шилжилтийн хөтөлбөрийн хүрээнд гадаад валютын нөөцөөс тодорхой хэмжээг ногоон бонд худалдан авахад зарцуулах тухай мэдээлсэн бөгөөд тус хөтөлбөр 2030 оныг хүртэл үргэлжлэхээр байна.
- **Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант улсын эдийн засгийн өсөлт 5-р сард 0.8 хувийн өсөлттэй гарсан нь 1.5 хувийн төсөөллөөс доогуур байв.** Хэдий тийм ч Ройтерс агентлаг 3-р улирлын өсөлтийн төсөөллийг 2.4 хувь байсныг нэмэгдүүлж 2.5 хувьд хүргэжээ. Улмаар 2021 оны өсөлтийн төсөөллийг 0.5 хувиар нэмэгдүүлж 6.7 хувь байхаар, 2022 оны 5.2 хувийн төсөөллийг хэвээр хадгалав. Төсөөллийг сайжруулахад вакцинжуулалтын үйл явц гол нөлөөг



үзүүлж, эрүүл мэндийн системийн эрсдэл буурна гэж тооцсон байна. Тус улсын инфляц энэ улиралд 2.2 хувь, ирэх улиралд 2.7 хувьд хүрэх төсөөлөлтэй байна.

- **Европын Төв банкны тэргүүн Кристин Лагарде цахим мөнгөний шилжилтийг ирэх 2 жилд хийхээр төлөвлөж буйгаа зарлалаа.** Ковид-19 цар тахал болон бусад гамшигт үзэгдэлд зайлшгүй авах арга хэмжээний нэг бол бэлэн мөнгө, зоосны хэрэглээг бууруулж, цахим мөнгөний хэрэглээг нэмэгдүүлэх шаардлагатай тухай мэдээлэв. Энэхүү шилжилтийн бүтэц ямар байх, Төв банкаар хэрхэн баталгаажих талаар судалгааны ажил хийгдэж байна.
- ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин өнгөрсөн 4-р сард дэд бүтэц, эрүүл мэнд, боловсролын салбарыг дэмжих **2 жилийн хугацаатай, 5.4 тэрбум ам.долларын (400 тэрбум рубль) эдийн засгийг сэргээх хөтөлбөрийг зарласан.** Уг хөтөлбөрийн нөлөөгөөр төсвийн алдагдал 2.8 их наяд рубль буюу ДНБ-ий 2.4 хувьд хүрнэ гэж тооцоолж

байсан хэдий ч татварын орлого нэмэгдсэнээр төсвийн алдагдал ДНБ-ий 1 хувьд хүрэх төлөвтэй байгаа тухай тус улсын сангийн сайд Антон Силуанов мэдээлж байв. Хэрэв газрын тосны үнэ энэ оны турш 1 баррель нь 75 ам.долларт хадгалагдах тохиолдолд тус улсын төсөв ДНБ-ий 3 хувьтай тэнцэхүйц хэмжээний ашигтай гарах хүлээлттэй байгаа тухай Renaissance Capital-ийн ерөнхий эдийн засагт мэдээллээ.

Эх сурвалж:

1. Market watch, [U.S. job openings hit record 9.2 million, but businesses can't find enough workers to fill them](#)
2. CNBC, [Inflation climbs higher than expected in June as price index rises 5.4%](#)
3. Reuters, [UK economic recovery to continue but new COVID-19 strains a threat: Reuters poll](#)
4. Reuters, [Russia heading for 2021 budget surplus, even with Putin spending goal -analysts](#)
5. Financial times, [Iron ore miners struggle to boost output even as demand soars](#)
6. Reuters, [OPEC+ agrees oil supply boost after UAE, Saudi reach compromise](#)
7. Markets Insider, [3 reasons why gold prices have struggled lately, according to Bank of America](#)
8. CNBC, [Bank of Japan cuts growth forecast, outlines climate scheme](#)

2

БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

Бодлогын арга хэмжээ

- **Заавал байлгах нөөцийн хувийг бууруулах шийдвэр гаргав.** Үүний нөлөөгөөр 1 их наяд юанийг (154 тэрбум ам.доллар) чөлөөлж, эдийн засагт нийлүүлэх боломжтой болж байна.

Эдийн засгийн голлох индекс, үзүүлэлтүүдийн өөрчлөлт

- **БНХАУ-ын эдийн засгийн өсөлт** 2-р улиралд 8.1 хувьд хүрнэ гэж Ройтерс

агентлаг урьдчилсан тооцоо хийж байсан ч хүлээлтээс ялимгүй доогуур буюу **7.9 хувиар өссөн** гүйцэтгэлтэй гарлаа.

- Эдийн засгийн өсөлт 6 хувийн зорилтыг давж, цар тахлын өмнөх үеийн түвшинд хүрсэн боловч дотоодын сэргэлт жигд бус байгаа, олон улсад КОВИД-19 цар тахлын дэгдэлт өндөр хэвээр байгаа зэрэг нь эрсдэл буураагүйг харуулж байна. Ажил эрхлэлт, өрхийн орлого, өрхийн хэрэглээ, боловсруулах



салбарын хөрөнгө оруулалт, үйлчилгээний сектор болон хувийн компаниудын үйл ажиллагаа харахан цар тахлын өмнөх түвшинд хүрээгүй байна.

- Жижиглэн худалдааны салбар 6-р сард Ройтерс агентлагийн төсөөлсөн 11 хувиас давж 12.1 хувиар өсөхөд ус, ундааны худалдаа жилийн өмнөх үеэс 29.1 хувиар өссөн, ресторан болон катерингийн үйлчилгээ 6-р сард өмнөх сараас 2.6 хувиар өссөн зэрэг нь чухал хувь нэмэртэй байв. Хэдий тийм ч БНХАУ-ын төмөр болон цементийн үйлдвэрлэл өмнөх сараас буурсан нь оны хоёрдугаар хагаст эдийн засаг түүхий эдэд тулгуурласан хөрөнгө оруулалтаас илүүтэй хэрэглээнд суурилж өсөх, улмаар импортын эрэлт бага байх магадлалтайг харуулж байна. Цар тахлын дараах V хэлбэрийн сэргэлт нь голчлон экспорт болон хөрөнгийн захаар тэтгэгдэж байсан бол энэхүү хэрэглээгээр өдөөгдсөн өсөлт нь илүү тогтвортой байх хүлээлттэй байна.
- Энэ оны 2-р хагаст эдийн засгийн өсөлт эхний хагасаас арай доогуур байх хүлээлттэй байна. Суурь үеийн нөлөөнөөс гадна оны 2-р хагаст дэлхий нийтээр үйлчилгээнд илүү их мөнгө зарцуулж, энэ нь БНХАУ-ын экспортын секторт сөргөөр нөлөөлөхөөр байна.
- **БНХАУ-ын экспорт 6-р сард хүлээлтээс давж 32.2 хувиар өссөн** бол суурь үеийн нөлөөгөөр оны 2-р хагаст экспортын өсөлт удаашрахаар байна.
- **Үйлдвэрлэлийн үнийн индекс (PPI)** энэ оны 6-р сард өмнөх оны мөн үеэс 8.8 хувиар нэмэгдсэн нь голлох

төсөөлөл гаргадаг байгууллагуудын хүлээлттэй нийцтэй байв. Харин 7-р сард 8.6 хувь болж өсөлтийн хурд буурахаар байгааг шинжээчид мэдээллээ.

- Түүхий эдийн салбарын нийлүүлэлтийг хангаж, үнийг тогтворжуулах дотоодын бодлогын үр дүнд зах зээлийн эрэлт, нийлүүлэлт тогтворжиж, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үнийн өсөлт удааширсан зэрэг сайн үр дүн гарч байна.
- **Хэрэглээний үнийн индекс (CPI)** 6-р сард өмнөх оны мөн үеэс 1.1 хувиар өссөн нь хүлээлтээс¹ доогуур үзүүлэлт юм. Түүнчлэн, хэрэглээний үнийн индексээр тооцсон инфляц 7-р сард 0.8 хувьтай байх төсөөлөлтэй байна.
 - Инфляц ийнхүү бага гарсан нь хүнсний үнийн дефляцаас голлон шалтгаалсан бөгөөд (өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.7 хувиар буурсан) үүнд гахайн махны үнийн бууралт гол нөлөөтэй байв. Гахайн махны үнэ 5-р сард жилийн өмнөх үеэс 23.8 хувиар буураад байсан бол 6-р сард 36.5 хувиар буурчээ.
 - Үнийн хэлбэлзэл ихтэй хэсэг болох хүнс болон эрчим хүчний үнийг хассан суурь инфляц 6-р сард өмнөх сарын гүйцэтгэлтэй ойролцоо буюу 0.9 хувьтай байв. Түүнчлэн, БНХАУ-ын инфляцын зорилт өмнөх онд 3.5 хувийн орчимд байсан бол 2021 онд зорилтоо бууруулж 3 хувийн орчимд байхаар зарласан байна.

Хөрөнгө оруулалт, худалдаа

- **БНХАУ-ын үндсэн хөрөнгийн хуримтлал (fixed asset investment)** 2021 оны эхний хагас жилд өмнөх оны

¹ Bloomberg, The Wall Street Journal 2-уул 1.2 хувь байхаар төсөөлж байсан бол Ройтерс агентлагийн төсөөлөл 1.3 хувьтай байсан.



мөн үеэс 12.6 хувиар өссөн нь эхний 5 сарын 15.4 хувийн өсөлтөөс удааширсан дүн боллоо. Эхний хагас жилд хувийн салбарын хөрөнгө оруулалт 15.4 хувиар, тэр дундаа өндөр технологийн үйлдвэрлэлийн салбар дахь хөрөнгө оруулалт 23.5 хувиар нэмэгджээ.

- БНХАУ-ын эрх баригчид **6 тэрбум ам.долларын өртөг бүхий үндсэн хөрөнгийг нэмэгдүүлэх 7 төслийг** өнгөрсөн 6-р сард баталлаа. БНХАУ-ын эдийн засаг хараахан бүрэн сэргээгүй, элдэв хүндрэл сорилтуудтай тулгарсаар байгаа өнөө цагт эдийн засгийн сэргэлтийг дэмжсэн, үр дүнтэй, цагаа олсон шийдвэр гэж үзэж байгаагаа мөн мэдэгдсэн.
- БНХАУ-д автомашины худалдаа 2021 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс **27 хувиар нэмэгдсэн** боловч цар тахлын өмнөх түвшинд хараахан хүрээгүй байна. Түүнчлэн, 6-р сард **олон улсад процессорын чипийн хомсдол бий болсон нь автомашины үйлдвэрлэл болон борлуулалтад сөргөөр нөлөөлөв.**
 - 6-р сард суудлын автомашины үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 13.7 хувиар буурсан бол борлуулалт 11.1 хувиар багасч 1.6 саяд хүрсэн байна. Ийнхүү сүүлийн 2 сар дараалан БНХАУ-ын автомашины үйлдвэрлэл болон борлуулалт буураад байна.
 - БНХАУ-ын эдийн засгийн сэргэлтийн талаарх худалдан авагчдын болгоомжлол болоод АНУ-тай хийж буй худалдааны дайн зэргээс шалтгаалж БНХАУ дахь автомашины эрэлт бага зэрэг буурчээ. Хэдий тийм ч БНХАУ-ын дотоодын үйлдвэрийн суудлын автомашины борлуулалт өсөж, зах зээлд эзлэх жин нь 6 орчим хувиар нэмэгдсэн байна.

Түүхий эдийн импорт, үйлдвэрлэл

- БНХАУ-ын **6-р сарын нүүрсний импорт өмнөх оны мөн үеэс 12.3 хувиар, өмнөх сараас 34.9 хувиар өсөв.** Нүүрсний дундаж үнэ \$92/тонн байсан нь тонн тутамд өмнөх оны мөн үеэс 25.2 ам.доллараар, өмнөх сараас 5.97 ам.доллараар өссөн дүн боллоо. Эхний хагас жилийн нийлбэр дүнгээр Индонез улс хамгийн их нүүрс борлуулсан бол Канад, Колумб, АНУ зэрэг алс холын нүүрс нийлүүлэгчид 100-аас дээш хувийн өсөлттэй байв. Харин БНХАУ-ын дотоодын нүүрсний үйлдвэрлэл сүүлийн 3 сар дараалан агшсан байна. Түүнчлэн, БНХАУ энэ оныг дуустал Австралиас нүүрс импортлох магадлал бага байгаа тул оны хоёрдугаар хагаст Австралийн бус нүүрсний эрэлт өндөр байж, импорт нэмэгдэх хүлээлттэй байна.
- Монгол улсын дотоод дахь КОВИД-19 цар тахлын тархалтаас шалтгаалж Монголын нүүрсний нийлүүлэлт багассан үед АНУ-аас БНХАУ руу **өндөр үнэтэй нүүрс нийлүүлж, нийлүүлэлтийн хомсдлын тодорхой хэсгийг нөхөж байна.** Тухайлбал, 2021 оны 7-р сарын 16-ны Кеплерийн каргоны мэдээнээс харахад 570 мянган тонн нүүрс (ихэнх нь коксжих нүүрс) БНХАУ руу ачигдсан байна. Өмнө нь 4-р сарын эхээр 310 мянган тонныг БНХАУ руу ачиж байсан нь хамгийн түүхэн дэх хамгийн өндөр хэмжээгээр бүртгэгдсэн бол сүүлийн ачилтын хэмжээ үүнээс 84 хувиар өссөн дүн юм. Өнгөрсөн 6-р сард АНУ-аас 740 мянган тонн нүүрс БНХАУ руу экспортолсон бол энэ сард 9.5 хувиар өсөж 810 мянган тоннд хүрэх тооцоотой байна.
- БНХАУ-ын эрчим хүчний хорооны мэдээлснээр 2021 оны эхний хагас жилд БНХАУ-ын **эрчим хүчний хэрэглээ жилийн 16.2 хувиар өссөн байна.**



- **Гангийн үйлдвэрлэл 6-р сард 93.9 сая тонн байсан нь өмнөх сараас 5.6 хувиар буурсан, өмнөх оны мөн үеэс 1.5 хувиар өссөн дүн юм. Энэ онд БНХАУ-ын Коммунист намын 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотойгоор Засгийн газраас байгаль орчны хяналтаа сайжруулж, гангийн үйлдвэрлэлээ өмнөх оны түвшин болох 1.065 тэрбум тооноос нэмэгдүүлэхгүй байх шийдвэр гаргасан. Эхний хагас жилийн гангийн үйлдвэрлэлийг харвал 563.33 сая тонн ган үйлдвэрлээд (өмнөх оны мөн үеэс 11.8 хувиар өссөн) байгаагаас үзвэл оны 2-р хагаст гангийн үйлдвэрлэл удаашрахаар байна.**

Эх сурвалж:

1. *China's GDP grew 7.9% in the second quarter; retail sales beat expectations, CNBC*
2. *China approves 7 fixed-asset investment projects worth \$6 bln in June, Reuters*
3. *China's More Balanced Recovery Gives Support to Global Rebound, Bloomberg*
4. *China's June crude steel output down 5.6% m/m on production curbs, Reuters*
5. *China's auto sales up 27% in 2021, but hurt by chip shortage, AP news*
6. *China's factory-gate prices cool, inflation eases in June, CGTN*
7. *China registers steady investment growth in H1, Xinhua*

3

МОНГОЛ УЛСЫН ЭКСПОРТЫН ГОЛ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ

| Бодит гүйцэтгэл | | | | | | | Товч тайлбар |
|---------------------------|-------------------------------|----------|--------|---------|--------------|-------|--|
| | Үнэ (-1 day) 2021/07/20 | Өөрчлөлт | | | | YoY | |
| | | daily | weekly | monthly | year to date | | |
| Зэс | 9336.0 | 1.2% | -0.8% | 2.0% | 20.5% | 43.8% | Дэлхийн улс орнууд уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх чиглэлд авч буй бодлогууд нь сэргээгдэх эрчим хүч, байгальд ээлтэй үйлдвэрлэлийг дэмжиж байгаа бөгөөд энэ нь зэсийн эрэлтийг нэмэгдүүлэх гол хөшүүрэг болж байна. БНХАУ зэсийн үнийн өсөлтөөс сэргийлэх зорилгоор улсын зэсийн нөөцөөс зах зээлд нийлүүлэхээр төлөвлөж буй мэдэгдлийн дараа өмнөх долоо хоногийн зэсийн үнэ буурсан хэдий ч нийт нийлүүлэх хэмжээ хүлээлтээс бага байсан нь 7-р сарын 20-ний байдлаар зэсийн үнэ эргээд өсөхөд нөлөөлөв. |
| Төмрийн хүдэр | 208.9 | 0.1% | -1.6% | 1.1% | 36.6% | 94.7% | БНХАУ-ын гангийн үйлдвэрлэл энэ онд өмнөх оны түвшнээс давахгүй байх шийдвэр гарсан тул энэ оны үлдсэн саруудад гангийн үйлдвэрлэл оны эхний хагасаас бага байхаар хүлээгдэж байна. Үүнтэй холбоотойгоор төмрийн хүдрийн үнэ буурч эхэллээ. Хэдий тийм ч ажиллах хүчний хомсдол, цаг агаарын хүндрэл зэргээс шалтгаалж төмрийн хүдрийн нийлүүлэлт хурдтай нэмэгдэх боломжгүй байгаа тул төмрийн хүдрийн үнэ цаашид огцом унахгүй байх хүлээлттэй байна. |
| Алт | 1810.3 | -0.1% | 0.1% | 1.5% | -4.7% | -0.4% | Төв банкуудын алтны худалдан авалт 2020 онтой харьцуулахад 60 хувиар багассан болон үнэт эдлэлийн бизнес эрхлэгчдийн борлуулалт буурч буй нь алтны эрэлт саарахад нөлөөлж байна. Ковид-19 цар тахлын делта хувилбар нь алтны зах зээлийн тодорхой бус байдлыг үүсгээд байна. |
| Газрын тос (Брент) | 69.4 | 1.1% | -9.3% | -7.4% | 35.7% | 60.2% | Газрын тосны үнийн өсөлтийг намжаах зорилгоор 8-р сараас 12-р сарын хооронд газрын тосны нийлүүлэлтийг нэмэгдүүлэхээр (OPEC+)-н сайдууд тохиролцсон нь өнгөрсөн долоо хоногт газрын тосны үнэ буурахад нөлөөллөө. Гэвч 7-р сарын 21-нээс үнэ буцаж өссөн. |